

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ
2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2022 оны 2 дугаар сарын 28-ны өдөр

№	Хийсэн ажил /чиглэлээр/	Гүйцэтгэсэн ажлын төрөл дараахь 4-н аль нэгийг сонгож тэмдэглэгээ хийх (✓)			
		Тулгамд-сан ажил	УИХ, ЗГ-т өргөн барьсан	Салбарын хүрээнд хийгдсэн	Шинэлэг ажил
I	Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр				
1.	“Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга, тэмдэглэлийн төсөл болон холбогдох тооцоо судалгааг боловсруулан 2021 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” Засгийн газрын 63 дугаар тогтоолоор 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс хүн амын амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан 460.5 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 500.0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 400.0 төгрөгөөр шинэчлэн тогтоов.		✓		
2.	Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг Нийгмийн Бодлогын Байнгын хорооны зөвлөхүүдэд танилцуулах, мэдээлэл солилцох хэлэлцүүлгийг зохион байгуулав.		✓		
3.	Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг Улсын Их Хурлын даргын зөвлөх Д.Лүндээжанцан болон Нийгмийн Бодлогын Байнгын хорооны зөвлөх Ц.Товуусүрэн нарт танилцуулж, холбогдох асуултад хариулан мэдээлэл солилцох хэлэлцүүлгийг зохион байгуулав.		✓		
4.	Хөдөлмөр нийгмийн хамгааллын Төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай гэрээ байгуулах арга хэмжээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хэрэгжүүлсэн ажил болон анхаарах асуудлуудын талаар танилцуулга, мэдээллийг нэгтгэн бэлтгэв.			✓	
5.	Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, А.Адъяасүрэн, Ц.Туваан нарын санаачлан боловсруулсан Тэтгэврийн доод хэмжээг индексжүүлэх тухай хуулийн төсөлд санал боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 1/394 дугаар албан бичгээр хариуг хүргүүлэв.		✓		
6.	Засгийн газрын 2022 оны 36 дугаар тогтоолоор “Хүүхдийн мөнгөн хуримтлалыг Төрийн санд байршуулан хуримтлуулах, бүртгэх, олгох журам”, 2022 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Тогтоолд өөрчлөлт орох тухай/ халамжийн тэтгэврийг нэмэгдүүлэх/” тухай тогтоолыг харьяа агентлагт хэрэгжүүлж ажиллах чиглэлийн хамт хүргүүлэв.			✓	
7.	УИХ-ын гишүүдэд зориулж Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын зорилтуудын биелэлтээр Ярианы сэдэв, түгээмэл асуулт, хариултыг нэгтгэн боловсруулж, мэдээллээр хангав.		✓		
8.	Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийн хүрээнд ажиллагчдын нийгмийн даатгал төлсөн шимтгэлээс тодорхой хувийг хадгаламж хэлбэрээр банканд байршуулж хүү бодох замаар тухайн иргэнийг тэтгэвэрт гарахад үүсэх хуримтлалын загвар схемийг боловсруулж удирдлагад танилцуулав.				✓
9.	Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төслийг Цахим хөгжил, харилцаа, холбооны яам, Стандарт хэмжил зүйн газар зэрэг холбогдох төрийн байгууллагын төлөөлөлд хэлэлцүүлж, саналыг тусган ажиллаж байна.			✓	
Бодлого төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр					
10.	Нийгмийн халамжийн шинэчлэлийн талаар МонголHD телевизтэй 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдөр уулзалт зохион байгуулав. Хамтран ажиллах хүрээнд нэвтрүүлгийн агуулга бэлтгэн, нэвтрүүлгийн багт Нийгмийн халамжийн шинэчлэлийг танилцуулах сургалтыг 2021 оны 02 дугаар сарын 16-ны өдөр телевизийн байранд зохион байгуулав. Түүнчлэн нэвтрүүлэг, ярилцлагад орох зочдын нэрсийн жагсаалтыг гаргаж ярилцлагын агуулгыг зочид тус бүрээр бэлтгэв.			✓	

11.	Тайгад амьдардаг цаатан иргэдээс ирсэн 30 гаруй өргөдлийг судлан яамны удирдлагуудад танилцуулав. Энэ хүрээнд 2021 оны 02 дугаар сарын 14-ний өдөр ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга болон Бодлого төлөвлөлтийн газраас Хөвсгөл аймгийн ХХҮГ, НДХ-тэй онлайн хурал зохион байгуулж цаатан иргэдийн өргөдлийг судлан хамрагдах боломжтой иргэдийн өргөдлийг шуурхай шийдвэрлэх, журамд өөрчлөлт оруулах санал хүсэлтийг ирүүлэх чиглэлийг өгөв.			√	
12.	Дэд сайдын ахалсан нийгмийн халамжийг зорилтот бүлгийн хэрэгцээнд нийцүүлж, амьжиргааг нь дээшлүүлэхэд чиглүүлэх, үйлчилгээний нэр төрлийг оновчтой тогтоох, чанар хүртээмжийг сайжруулах санал, дүгнэлт боловсруулан хэрэгжүүлэхээр байгуулагдсан ажлын хэсэгт Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд нийгмийн халамжийн сангаас хөнгөлөлт, тусламж авах эрхтэй холбоотой орсон өөрчлөлтүүдийн талаар танилцуулга бэлтгэлээ. Мөн нийгмийн халамжийн бодлогоор дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих тухай олон улсын туршлагын мэдээллийг бэлтгэлээ. Мөн энэ талаар бусад салбарын эрх зүйн баримт бичгүүдэд тусгагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн хөнгөлөлт, дэмжлэгийн талаарх мэдээллийг яамдаас авч нэгтгэн нэгтгэн боловсруулж байна.			√	
13.	Төрийн байгууламжийн бүтээмжийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, ажиллаж амьдрах орчин нөхцөл бүрдүүлэх хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх ажлын саналыг боловсруулан хүргүүлэв. Хууль эрх зүйн баримт бичгийн төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, түүн дотроо төрийн бус байгууллагаар зөвлөх үйлчилгээний ажлыг гэрээлэн гүйцэтгүүлэх, хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн ажил, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, ажиллаж амьдрах орчин нөхцөл бүрдүүлэх хүрээнд хүртээмжийн үнэлгээ хийж, зөвлөмж боловсруулах зэрэг ажлын саналыг хүргүүлсэн. -Дипломат төлөөлөгчийн газруудаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, бусдын адил ажиллаж амьдрах боломж, нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор манай улсад тулгамдаж буй асуудлаар санал хүргүүлээ. Тодруулбал, Ази, номхон далайн бүс нутгийн орнууд болон Англи, Америк зэрэг орны хөгжлийн бэрхшээлтэй залуу гэр бүлийг дэмжих бодлого, оюун болон сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх тогтолцоо зэргийг судлуулах санал боловсруулсан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Оросын холбооны улстай байгуулсан санамж бичгийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг орон байраар хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг судлах, туслах хэрэгсэл болон нийгмийн халамжийн тогтолцоог судлах, хөгжүүлэх төвүүд болон сэргээн засах, протезын үйлдвэрийг судлах зэрэг чиглэлээр хамтран ажиллах санал боловсруулж хүргүүлсэн. -Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг “Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна” гэж заасны хэрэгжилтийг хангах, санал, дүгнэлт боловсруулах ажлын хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах орчин нөхцлийг бүрдүүлэх, багш, ажилчдын хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр санал боловсруулж хүргүүлээ.			√	
14.	“Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд боловсруулагдаж буй нийгмийн халамж, орчны хүртээмж, хөдөлмөр эрхлэлтийн тайлантай уншиж танилцан санал хүргүүлээ.			√	
15.	Гадаад харилцааны яамнаас “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гадаад улс орнуудтай хамтран ажиллах, тэргүүн туршлагыг нэвтрүүлэх боломжийн талаар Дипломат төлөөлөгчийн газруудаар хийлгэх судалгааны санал хүргүүлээ.			√	
16.	ХНХ-ын сайдын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/05 дугаар тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд нийгмийн халамжийг зорилтот бүлгийн хэрэгцээнд нийцүүлж, амьжиргааг дээшлүүлэхэд чиглүүлэх, үйлчилгээний нэр төрлийг оновчтой тогтоох, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах хүрээнд санал дүгнэлт боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Энэхүү ажлын			√	

	хүрээнд “Хүүхэд хөгжүүлэх төвийн үйл ажиллагааг бусад халамжийн болон хүүхэд хөгжил, хамгааллын үйлчилгээтэй уялдуулах боломжийг судалж, санал боловсруулах” багийн хурлыг зохион байгуулав.				
17.	“Батгэрэлт-Ирээдүй” төрийн бус байгууллагад асруулж буй иргэдэд амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох сургалт зохион байгуулах тухай Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/32 дугаар тушаалын дагуу тус төрийн бус байгууллагатай хамтран ажиллах 2022 оны 02 сарын 28-ны өдрийн 3/40 дугаартай гэрээ байгуулав.			√	
18.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголын улаан загалмай нийгэмлэгийн хооронд төрийн зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэх, хамтран ажиллах тухай гэрээг ХНХ-ын сайд А.Ариунзаяа, Монголын улаан загалмай нийгэмлэгийн ерөнхий нарийн бичгийн дарга Н.Болормаа нар 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 1/29 дугаартай гэрээг байгууллаа.			√	
19.	Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2022 оны 01 дүгээр тогтоолоор Ахмад настны тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, ахмад настны асрамжийн газрын үйл ажиллагаатай танилцах, санал дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Ажлын хэсгийн ахлагч УИХ-ын гишүүн Б.Жаргалмаа, УИХ-ын гишүүн Д.Сарангэрэл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Ундрал, ажлын дэд хэсгийн гишүүд 2022 оны 2 дугаар сарын 10-ны өдөр нийслэл хотод үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын байгууллага, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай асрамжийн 2 газарт очиж ажиллав.			√	
20.	Хүүхэд хамгааллын үйлчилгээ, үйлчилгээний санхүүжилтийг тооцох эрх зүйн орчныг сайжруулах ажлын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, 27 дугаар хамтарсан тушаалаар “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг шинээр батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэв.			√	
21.	“Хүүхэд харах үйлчилгээний шалгуур, болзол, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих журам”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/26 дугаар тушаалаар шинэчлэн батлуулж нөлөөллийн шинжилгээ, саналын товъёог хийж Хууль зүйн яаманд албан бичгээр хүргүүлэн Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэв.			√	
22.	“Хүүхэд харагчийг бэлтгэх сургалтын жишиг хөтөлбөрийг ХНХ-ын сайдын 2022 оны А/38 дугаар тушаалаар батлуулав.			√	
23.	Залуучуудын хөгжлийн төв /ЗХТ/-ийн үйлчилгээний аргачлалын төслийг эцэслэн боловсруулж, төслийг ЗХТ-ийн ажилтан, албан хаагчдаар хэлэлцүүлж саналыг тусгаж байна.			√	
24.	“Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”-д нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судлан боловсруулж байна.			√	
III	Бодлогын хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр				
25.	Татан буугдсан “Капитал банк” ХХК-нд байршиж байсан нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг төлүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Засгийн газрын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанд танилцуулж, хэлэлцүүлэв.		√		
26.	“Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, эрх баталгаажуулах, эрх сэргээх шалгалтын журам”-ыг шинэчлэн боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/27 тоот тушаалаар батлуулав. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт албан бичгээр хүргүүлэв.			√	
27.	Тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг 10 хувилбараар боловсруулж, танилцуулгын хамт ҮСХ-ноос санал авахаар 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 378 дугаартай албан бичгээр, Нийгмийн даатгалын ерөнхий газарт 10 хувилбар тус бүр дээр бодолт хийлгэхээр 2022 оны 02 дугаар сарын 18 өдрийн 397 дугаар албан бичгээр тус тус хүргүүлэв.			√	
28.	Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын дэргэд ажиллах нэг талаас ажил олгогч, даатгуулагч, нөгөө талаас нийгмийн даатгалын байгууллагын хооронд гарсан саналын зөрүүг хянан шийдвэрлэх “Гомдлын шаардлагын зөвлөлийн дүрэм”-ийн төслийг шинэчлэн боловсруулж			√	

	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 01/285 тоот бичгээр санал авахаар Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэв.				
29.	Тус яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, мэргэжилтнүүд 2022 оны 02 дугаар сарын 11,12-ний өдрүүдэд Нийгмийн даатгалын ерөнхий газар, тус газрын дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын холбогдох ажилтнуудын хамт Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс болон Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст тус тус ажиллав.			√	
30.	“Петро Чайна Дачин Тамсаг” ХХК-иас Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулагдсанаас хойших хугацаанд цаг үеийн нөхцөл, шаардлагаар Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид орсон нэмэлт өөрчлөлтүүд нь “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-гээр гэрээлэгчтэй тохиролцсон татвар, шимтгэл, төлбөрөөс чөлөөлөгдөх заалтуудтай зөрчилдөж, тодорхойгүй нөхцөл байдал үүсээд байгаа талаар ирүүлсэн хүсэлтийн дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгоор хамтарсан ажлын хэсэг байгуулах тухай албан бичгийг Сангийн яам, Гадаад харилцааны яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд тус тус хүргүүлж, 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны холбогдох хүмүүстэй уулзалт зохион байгуулав.			√	
31.	Монголбанкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг 2021 оны 6 дугаар сараас 11 дүгээр сар хүртэлх хугацаанд банкууд хэрхэн хангаж ажилласан талаарх Сангийн яамнаас ирүүлсэн мэдээллийг Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн Ажлын албанд хүргүүлэв.			√	
32.	Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Жагсаалт, шалгуур үзүүлэлт, маягт шинэчлэн батлах тухай” А/807, А/216 дугаар хамтарсан тушаал батлагдсантай холбогдуулан уг тушаалын /асаргааны тэтгэмж/ хэрэгжилтийг хангуулах талаар Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газарт чиглэл хүргүүлэв.			√	
33.	Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2022 оны 01 дүгээр тогтоолоор Ахмад настны тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, ахмад настны асрамжийн газрын үйл ажиллагаатай танилцах, санал дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн Хөвсгөл, Увс, Орхон аймагт ажиллах удирдамж, холбогдох төсөв, хөтөлбөрийг гаргав.			√	
34.	21 аймаг, 9 дүүргийн халамжийн нийгмийн ажилтнуудын цалингийн мэдээллийг аван, цаашид нийгмийн ажилтнуудын цалингийн шатлалыг нэмэгдүүлэхээр тооцоо судалгаа хийж байна.			√	
35.	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа “Үр дүнтэй нийгмийн халамжийн системийн чадавхи бэхжүүлэх нь ТТ 9893-МОН” төслийн хүрээнд ХНХЯ-ны бодлого боловсруулагчид, мэргэжилтнүүдэд зориулсан 8 удаагийн цуврал семинарыг амжилттай зохион байгуулав.			√	
36.	Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороонд нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хороололд амьдарч байгаа амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур, зуухыг нь шинэчлэх шаардлагатай өрхийн мэдээллийг гарган Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороонд хүргүүлэв.			√	
37.	Сайдын өгсөн үүрэг чиглэлийн дагуу Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, холбогдох хуулиудын шинэчлэлийн төсөлд төрийн бус байгууллагуудын саналыг тусгах хамтран ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг ХНХ-ын сайдын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/05 тушаалаар байгуулан ажиллаж байгаа бөгөөд тус ажлын хэсгийн хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажлын хэсгийн даргаар батлуулж, ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлэн дэд ажлын хэсгүүд ажиллаж байна.			√	
38.	Хүн амын бүлгүүдийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд 2021 онд “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох”, “Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих”, “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” гэсэн 5 үндсэн хөтөлбөрийн 17 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс 2022 онд “Ногоон ажлын байр хөтөлбөр”, “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” гэсэн 2 хөтөлбөрийг шинээр			√	

	хэрэгжүүлэхээр шийдвэрлэн нийт 7 хөтөлбөр, 28 арга хэмжээг батлаад байна. Мөн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны төсвийн хуваарийг ХНХ-ын сайдын тушаалаар баталлаа.				
39.	Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг салбарын яамдаас авч нэгтгэн боловсруулж, ХШҮДАГ-аар үнэлгээ хийлгэж байна.			√	
40.	Нэгдсэн Үндэстний байгууллагын Ерөнхий Ассамблейн 77 дугаар чуулганд танилцуулагдах “Далд эдийн засаг дахь орчин үеийн боолчлолын хэлбэрүүд” сэдэвт тайланд тусгагдах мэдээллийг асуулгын хүрээнд бэлтгэж байна. Энэхүү ажлын хүрээнд Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэгчдийн өнөөгийн дүр төрх, хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн харилцаа, албан бус хөдөлмөр эрхэлж байгаа учир шалтгаан, албан бус хөдөлмөр эрхлэгчдийн зүгээс албан хэлбэрт шилжих боломж, арга зам, төр, захиргааны байгууллагуудаас хэрэгжүүлж буй бодлого арга хэмжээний талаарх мэдээллийг тусгав.			√	
41.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дэмжлэг үзүүлж ажиллах зөвлөхийн ажлын даалгаврыг боловсруулж, НҮБ-ын Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих төсөлд хүргүүлэв.			√	
42.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Үндэсний хорооны хурлыг 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдөр цахимаар зохион байгуулж дараах асуудлуудыг хэлэлцэв. Үүнд: - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Үндэсний хорооны 2022 оны төлөвлөгөө, - Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2022 оны төлөвлөгөөг гишүүдийн санал, зөвлөмжийг тусган батлуулж, Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэв. - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр сургалт зохион байгуулах бүртгэлийн гэрчилгээ шинээр авах болон төрөл нэмүүлэх байгууллагуудын талаар шийдвэрлэв.			√	
43.	Ази, Номхон далайн орнуудын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн арван жил (2013-2022)-ийн хэрэгжилтийн нэгдсэн тайланд хүргүүлэхээр “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн талаарх тоон мэдээг 2017-2021 оны байдлаар бэлтгэн гаргав.			√	
44.	Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлт болон төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн талаарх 2022 оны 01 дүгээр сарын тоон мэдээллийг нэгтгэн гаргав.			√	
45.	Тус яамны зүгээс мэргэжлийн холбоод, ТББ-ын нөхцөл байдалтай газар дээр нь очиж, санал солилцох төлөвлөгөөний дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, холбогдох асуудал хариуцсан албаны хүмүүсийн хамт “Технологийн уур үйлдвэрлэгчдийн холбоо”-ны төлөөллүүдтэй уулзаж, үйл ажиллагаатай нь танилцлаа. Уг холбоо нь хөөсөнцөрийн үйлдвэр, хөнгөн блокны үйлдвэр, бетон хийцийн үйлдвэр, тоосгоны үйлдвэр, хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр, мах боловсруулах үйлдвэр, өөх тос, ноос ноолуур боловсруулах үйлдвэр зэрэг 12 салбарт үйл ажиллагаагаа явуулж байна.			√	
46.	Ази, Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг бодит болгох” Инчеоны стратегийн хэрэгжилтийн тайланг 2022 оны 03 дугаар сард Ази, Номхон далайн бүсийн нийгэм, эдийн засгийн хороонд хүргүүлэхээр тайлан боловсруулах салбар дундын ажлын хэсгийг ХНХС-ын А/24 тоот тушаалаар байгуулан мэдээллийг нэгтгэн ажиллаж байна. Энэ хүрээнд ажлын хэсгийг 2 удаа хуралдуулж, тайланг боловсруулж байна.			√	
47.	“Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын сургалт, арга хэмжээний удирдамж”-ийг боловсруулан Төрийн нарийн бичгийн даргаар батлуулав.			√	
48.	Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийг бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулахаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт төслийг хүргүүлэв.		√		
49.	“Нийгмийн ажлын талаарх бодлогын баримт бичиг боловсруулах, хэлэлцүүлэг зохион байгуулах” тухай Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/22 тушаалыг боловсруулж батлуулав.			√	
50.	“Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдэд нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх ажлыг боловсронгуй болгох, хэлэлцүүлэх тухай төслийг боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргаар, төсвийг НҮБ-ын хүүхдийн сангаар батлуулав.			√	

51.	Төрийн нарийн бичгийн даргын “Олон улсын хүүхдийн Найрамдал-2” зуслангийн дунд болон урт хугацааны хөгжлийн бодлого, стратеги боловсруулах тухай 2022 оны А/23 тушаалыг батлуулав.			√	
52.	-“Олон улсын хүүхдийн Найрамдал-2” зуслан байгуулах ажлын хүрээнд “Олон улсын хүүхдийн Найрамдал-2” зуслангийн дунд болон урт хугацааны хөгжлийн бодлого, стратеги боловсруулах зөвлөх үйлчилгээний зарыг яамны сайтад байршуулав. -Олон улсын хүүхдийн найрамдал зуслангийн их засвар, шинэчлэл /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/-ийн төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн хорооны нарийн бичгээр ажиллаж, холбогдох бүх үүргийг гүйцэтгэсэн ба 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдөр тендерийг зарласан.			√	
53.	Монгол Улсын Их Хурлын “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 2021 оны 67 дугаар тогтоолын хэрэгжилтийг гаргаж, 2022.02.10-ны өдрийн 3/315 тоот албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.		√		
54.	Хөдөлмөрийн тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиудыг холбогдох заалтыг хэрэгжүүлж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах байгууллагуудад хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах чиглэлийг ХНХ-ын сайдын 2022.02.08-ний өдрийн 01/268 тоот албан бичгээр Засгийн газрын гишүүд, Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын ерөнхий прокурор, Тагнуулын ерөнхий газар, Төрийн тусгай хамгаалалтын газар, Биеийн тамир, спортын улсын хороонд хүргүүлэв.		√		
55.	ХНХ-ын сайдын “Олон улс, тив, дэлхийн тэмцээн, наадамд оролцож, амжилт гаргасан хүүхдүүдийг шагнаж урамшуулах тухай” 2022 оны А/28 дугаар тушаалаар Хүүхдийн төлөө сангаас Нийслэлийн Баянгол дүүргийн “Наран” бүрэн дунд сургуулийн 11 дүгээр ангийн сурагч Н.Батболд, Нийслэлийн Хан-Уул дүүргийн 115 дугаар сургуулийн 6 дугаар ангийн сурагч Г.Урангоо, Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 62 дугаар сургуулийн 11 дүгээр ангийн сурагч Б.Ням-Эрдэнэ нарыг шагнаж урамшуулах 8.900.000 төгрөгийн зардлыг шийдвэрлүүлээ.			√	
56.	Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл 108-н дуудлага мэдээллийг 21 аймгаар нэгтгэн удирдлагуудад танилцуулав.			√	
57.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Нийгмийн хөгжилд эрчүүдийн оролцоо, манлайлал” үндэсний чуулганыг 2022 оны 3 дугаар сарын 14-ний өдөр Төрийн ордонд зохион байгуулахтай холбоотой бэлтгэл ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж, гүйцэтгээд байна. - ХНХ-ын сайдын 2022 оны А/14 дүгээр тушаалаар байгуулагдсан салбар дундын ажлын хэсгийг 3 удаа хуралдуулсан. - Чуулган зохион байгуулахаар 3 дэд ажлын хэсэг байгуулсан. Агентлаг дээр 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдсан. - Чуулганы хөтөлбөрийн төсөл боловсруулж, төсөлд ажлын хэсгийн гишүүдийн санал тусгасан. Чуулганы зорилго, зорилт, хүлээгдэж буй үр дүнгийн томъёололд ажлын хэсгийн гишүүд саналаа ирүүлж байна. - Чуулганы нээлтэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн хэлэх үгэнд тусгах саналын төслийг хамтран боловсруулсан. - Чуулганд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын танилцуулах үндсэн илтгэлийн төслийг боловсруулж байна. Илтгэлд салбаруудаас тусгах асуудлын төслийг ажлын хэсгийн холбогдох гишүүдээс 2 сарын 24-ний өдрийн 17 цагийн дотор ирүүлэхээр төлөвлөсөн. - Чуулганы панелистийн блиц танилцуулгын хүснэгтийг ажлын хэсгийн гишүүдэд 2 сарын 23-ны өдөр хүргүүлсэн. - Чуулганы бэлтгэл ажлын хүрээнд орон нутагтаа “Нийгмийн хөгжилд эрэгтэйчүүдийн оролцоо, манлайлал” сэдэвт дэд хэлэлцүүлгийг хийхээр албан тоот явуулж, нийслэл, орон нутгийн Нийгмийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтнүүд, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын удирдлагуудад цахим сургалт, танилцуулга хийж чиглэл хүргүүлсэн. - Чуулган зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд тайз засалтыг Онон гавъяаттай хамтран хийхээр дизайн гаргасан. - Соёлын яамтай уулзалт зохион байгуулж, урлагийн тоглолтын асуудлыг зөвшилцөж байна. Чуулганы дараа зохиогдох тоглолтын хөтөлбөр болон агуулгыг ярилцаж саналаа хүргүүлээ - Чуулганд хэлэх Ерөнхийлөгчийн үгийн төслийг бэлтгэн хүргүүлсэн.	√			

	<ul style="list-style-type: none"> - Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар Зардал батлах тухай тушаалыг боловсруулж, бэлтгэсэн. - Хэвлэл, мэдээлэл хариуцсан багаас шторк явуулах ажлыг хариуцаж хийхээр төлөвлөсөн. - Олон Улсын байгууллагууд руу албан тоот хүргүүлсэн. Ажлын шугмаар уулзахаар төлөвлөсөн. 				
58.	Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан орон нутгийн эмэгтэйчүүдийг чадавхижуулж, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, санхүүгийн боловсрол мэдлэг олгох зорилгоор “Эмэгтэйчүүд хамтдаа” чуулга уулзалтыг Сэлэнгэ аймагт зохион байгуулах ажлын удирдамжийг боловсруулж, шаардагдах төсвийг тооцоог хийж, Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/36 дугаар тушаалаар батлав. Мөн тушаалын дагуу уг ажлыг гүйцэтгэх төрийн бус байгууллагатай гэрээ байгуулав.			√	
59.	Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хүн ам, гэр бүлийн хөгжлийн хэсгийг боловсруулах зөвлөхийн ажлын даалгаврыг боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/37 дугаар тушаалаар батлав.			√	
60.	2022 оны 03-р сарын 14-25-ны өдрүүдэд АНУ-ын Нью Йорк хотноо болох НҮБ-ын Эмэгтэйчүүдийн аж байдлын комиссын 66 дугаар чуулганы бэлтгэл ажлын хүрээнд ерөнхий хуралдааны “Цаг уурын өөрчлөлт, орчны болон байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээрх бодлого, хөтөлбөрийн хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангаж, охид эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх нь” сэдэвт илтгэл, мөн чуулганы салбар хуралдааны “Хувьсан өөрчлөгдөж байгаа ажлын орчинд эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх нь” сэдэвт илтгэлийг тус тус бэлтгэв.			√	
61.	Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх хүрээнд эмэгтэйчүүдийн талаарх төрийн зарим чиг үүргийг Монголын эмэгтэйчүүдийн холбоогоор гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхээр 2022 онд байгуулах гэрээнд тусгах асуудлын чиглэлийг гаргаж ЗГХАгентлаг-Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газарт хүргүүлэв.			√	
62.	МУ-ын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.4, 24 дүгээр зүйлийн 24.2.5-д заасны дагуу 2010 оноос хойших хугацаанд хийж гүйцэтгэсэн цахим засаглал, харилцаа холбоо, өндөр технологи, инновацын бодлого, үйл ажиллагаатай холбогдолтой мэдээллийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэмжээнд нэгтгэн УИХ-ын Инноваци, цахим бодлогын байнгын хороонд хүргүүлэв.		√		
63.	Иргэн, аж ахуй нэгжид үзүүлж буй Төрийн үйлчилгээний судалгааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэмжээнд нэгтгэн Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 03/432 тоот албан бичгээр хариуг хүргүүлэв.			√	
64.	Хүүхэд, залуучуудын статистикийн үзүүлэлт тооцох аргачлал, мэдээлэл цуглуулах маягт нөхөх зааврыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/25 дугаар тушаалаар шинээр байгуулан, Үндэсний статистикийн хороон дээр хүүхдийн статистикийн аргачлал, залуучууд, гэр бүлийн маягт, нөхөх зааврыг шинэчлэх гэсэн 2 хурлыг зохион байгуулж, хүүхдийн статистикийн аргачлал батлах хүртэлх хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулав.			√	
65.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголын ахмадын холбоо хамтран аймаг, нийслэл, дүүрэг, яам, агентлаг, аж ахуйн нэгжийн ахмадын байгууллагын удирдах ажилтны улсын зөвлөгөөнийг цахимаар зохион байгууллаа. Зөвлөгөөнд нийт 800 гаруй ахмад цахимаар хамрагдаж, Төрийн байгууллага, Монголын ахмадын холбооноос хийж хэрэгжүүлж буй ажлын талаар мэдээлэл өгч, санал солилцов. Зөвлөгөөнд оролцогчдод ХНХЯ, түүний харьяа НДЕГ, ХХҮЕГ, ГБХЗХГ-аас ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулахад чиглэсэн бодлого үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч, санал солилцов.			√	
66.	-Нийслэлийн боловсролын газартай хамтран Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын төрийн болон хувийн өмчийн сургуулиудын нийт 130 гаруй сургалтын менежер, нийгмийн ажилтнуудад “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал” сургалтыг зохион байгуулав. -Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах зорилгоор Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын 17 дугаар дунд сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ангиудын 120 гаруй эцэг эхэд “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал” сургалтыг зохион байгуулав.			√	

67.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Мобиком корпораци хооронд 2019 онд байгуулсан Хамтын ажиллагааны Санамж бичгийн хэрэгжилтийн талаарх уулзалт зохион байгуулж, цаашид Санамж бичгийг сунгахаар тогтов.			√	
68.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын, Боловсрол, шинжлэх ухааны, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/220, А/475, А/812 дугаар шинэчлэн батлагдсан тушаалын хэрэгжүүлэхтэй холбоотой дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Боловсролын яамтай хамтран аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар, Нийслэлийн боловсролын хэлтсийн удирдлага 80 гаруй мэргэжилтэнд цахим танилцуулга хийсэн. - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоо, Боловсрол, шинжлэх ухааны яамтай хамтран онлайн 60 гаруй эцэг эх, иргэдийг хамруулан хэлэлцүүлэг зохион байгуулсан. - Тус тушаалыг хамтран батлуулсан Эрүүл мэнд, Боловсрол, шинжлэх ухааны яаманд тушаалыг хэрэгжилтийг хангаж ажилах тухай чиглэл хүргүүлэв. 			√	
69.	Азийн хөгжлийн банкны хүрээнд хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангаж үйлчилгээг сайжруулах төслийн хүрээнд хэрэгжиж буй олон нийтийн хэвлэл мэдээлэл олон нийтийн багцын хүрээнд хийгдсэн “Өнөөдөр сонины” Портежийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл явц хэлэлцүүлэгт оролцож мэдээлэл өгөв.			√	

----- оОо -----